



Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

Хүндэтгэлийн өдөр талархалтай байх

Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд Хүндэтгэлийн өдөр нь талархал, хайрын өдөр.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд дэлхий даяар цугласан байгаа хайрт ах, эгч нар минь ээ, ерөнхийлөгч Томас С.Монсон энэхүү Хүндэтгэлийн өдөр чуулган дээр намайг үг хэлэхийг хүссэнд би талархаж байна. Ариун Сүнс үгсийг маань зүрх сэтгэлд тань хүргэх болтугай хэмээн би залбирч байна.

Өнөөдөр би зүрх сэтгэлийн мэдрэмжийн талаар ярих гэсэн юм. Өнөөдрийн миний онцлох сэдэв бол талархал, ялангуяа Хүндэтгэлийн өдөрт талархах тухай байх болно.

Бид танихгүй нэгний эелдэг харилцаа, өлссөн үед өгсөн хоол, салхи шуургатай үед хоргодох дулаахан байр, эдгэрсэн яс, дөнгөж төрсөн хүүхдийн уйлах чимээ зэрэг олон зүйлд талархдаг. Бидний олон нь иймэрхүү мөчид мэдэрсэн талархлын мэдрэмжээ санадаг.

Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд Хүндэтгэлийн өдөр бол үнэндээ талархал, хайрын өдөр байдаг. Их Эзэн 1831 онд Миссуригийн

Жаксон гүнлэг дэх гэгээнтнүүдэд Бурханд хандан залбирч, талархдаг байх ёстой гэж зөвлөжээ. Эртний гэгээнтнүүдэд Хүндэтгэлийн өдрийг хэрхэн сахиж, залбирч, мацаг барих тухай илчлэлт өгсөн.¹

Их Эзэн тэдэнд төдийгүй мөн бидэнд ч Хүндэтгэлийн өдөр хэрхэн шүтэн биширч, талархлаа өргөх ёстой тухай хэлсэн. Та нарын мэдэж байгаачлан, хамгийн чухал нь бэлэг өгөгчдийг хайрлах бидний хайр юм. Хүндэтгэлийн өдөр хэрхэн талархаж, хайраа үзүүлэх талаар Их Эзэний үгс байдаг.

“Бибээр тэдэнд зарлиг болгон ийн хэлэв: Чи Их Эзэн Бурханаа бүх зүрх сэтгэлээрээ, өөрийн бүх хүчин чадал, оюун хийгээд чадлаараа хайрлах ёстой; мөн Есүс Христийн нэрээр чи түүнд үйлчлэх ёстой. . . .

“Чи Их Эзэн Бурхандаа бүх зүйлд талархах ёстой.

“Чи Их Эзэн Бурхандаа зөв шударга байдалд, бүр харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр золиослол өргөх ёстой.”²

Мөн бэлэг өгөгч Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт хайр, талархлаа илэрхийлээгүйн улмаас учрах аюулын талаар Их Эзэн: “Мөн бүх зүйл дээр түүний гарыг хүлээн зөвшөөрдөггүй, мөн түүний зарлигуудыг дуулгавартайгаар үл дагадаг тэднээс бусад хүмүүн ямар ч зүйлээр Бурханд гэм бурууг үйлддэггүй, эсвээс хэний ч эсрэг түүний уур хилэн дүрэлздэггүй”³ гэж бидэнд сэрэмжлүүлжээ.

Та нарын олонх нь Хүндэтгэлийн өдөр Бурханы адислалуудыг дурсан санаж, адисалсных нь төлөө талархах өдөр болгон үүнээсээ баяр баясгаланг олсон байгаа. Та нар нэгэн танил дууг санаж байгаа байх.

*Амьдралын эргүүлэгт автан
бүдчихдээ*

*Бүхнийг хэрэв алдсан гэж та
шантарвал*

*Адислал бүрээ тоол, нэг нэгээр
тоолж үз.*

*Бурханы хийснийг ухааран
та биширнэ.*

*Адислалаа нэг нэгээр тоолж үз.
Ивээлээ тоол, Бурханы хийс-
нийг сана.*

*Адислалаа нэг нэгээр тоолж үз.
Адислал бүрээ тоол, Бурханы
хийснийг сана. . . .*

*Сэтгэл зовон, хүнд ачаа та
үүрч байна уу?*

*Үүрэх загалмай тань хүнддэж
байна уу танд?*

*Адислал бүрээ тоол, сэтгэл
тань хөнгөрч*

*Өдөр бүр та баяр хөөртэй байх
болно.*⁴

Хүнд ачаа үүрч яваа хожмын үеийн гэгээнтнүүд надад захидал бичиж, над дээр айлчлан ирдэг. Заримд нь бүхнийг алдсан мэт санагддаг. Хүндэтгэлийн өдөр талархалтай байх талаар хэлэх миний зүйл эргэлзээг тань арилгаж, зүрх сэтгэлдээ, ялангуяа ариун ёслол бүр дээр энэ дууг дуулж эхлэхэд туслах байх гэж би найдан, залбирч байна.

Бидний талархаж болох нэг адислал бол Түүний нэрээр нэг, хоёр ба түүнээс дээш шавь нартай хамт цуглан ариун ёслолын цуглаандаа ирчихсэн байгаа явдал юм. Орноосоо ч өндийн босож чадаггүй байгаа хүмүүс байгаа. Бидний байгаа газарт байхыг хүссэн ч эмнэлэгт ажиллаж, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж эсвэл хаа нэгтээ цөл газар, ширэнгэн ойд амьнасаараа дэнчин тавин, цэргийн алба хааж байгаа болохоор ирж чадаагүй хүмүүс ч байгаа. Ядаж л өөр нэгэн гэгээнтэнтэй хамт, ариун ёслолоос хүртэх боломжтой байгаа нь бидэнд Бурханы энэрэл хайранд талархаж, хайраа үзүүлж эхлэхэд туслах юм.

Бошиглогч Иосеф Смит, сэргээгдсэн сайн мэдээний ачаар бидний тоолж болох өөр нэг адислал бол Бурханы эрх мэдэлтэй үйлчлэгчдийн бэлтгэж, адислан, түгээдэг ариун ёслолоос долоо хоног бүр хүртэх явдал юм. Бид эрх мэдэлтэй санваартны хэлж буй ариун ёслолын залбирлын үгсийг Тэнгэрлэг Эцэг таалдаг гэдгийг Ариун Сүнс бидэнд баталж байгаад талархаж болно.

Хамгийн агуу, хүлээж авна гэдэгтээ итгэлтэй байж болох адислал бол ариун ёслолыг хүртэж байхдаа өршөөгдсөн гэдгээ мэдрэх явдал юм. Түүнчлэн бид хязгааргүй золиослол хийж, нүглээс цэвэршигдэх боломжийг олгосон Аврагчаа хайрлах хайр, талархах талархал маань өсөн нэмэгдэж байгааг мэдэрнэ. Бид талх, уснаас хүртэж байхдаа Тэрээр бидний төлөө зовж шаналсныг санадаг. Бид бас Түүний бидний төлөө хийсэн зүйлд талархаж,

биднийг гэх Түүний хайр, Түүнийг хайрлах өөрсдийн хайрыг мэдэрнэ.

Хайрыг хүлээн авсан адислал маань бидэнд “үргэлж түүнийг санах”⁵ гэрээгээ сахихад хялбар болгодог. Тэр ч байтугай та нар миний нэгэн адил амлалтаа итгэлтэй сахих үед та нартай үргэлж хамт байлгана хэмээн Тэнгэрлэг Эцэгийн амласан Ариун Сүнсэнд талархах талархал, хайрыг мэдэрч болно. Бид энэ бүх адислалыг ням гараг бүр мөн эдгээр гэрээгээ санах бүрдээ тоолж, талархаж болно.

Хүндэтгэлийн өдөр нь мөн Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг хайрлаж, үйлчлэх баптисмын усанд хийсэн гэрээгээ санах төгс цаг юм. Энэ амлалтаа Хүндэтгэлийн өдөр биелүүлэхэд бидэнтэй хамт тэнд байгаа ах, эгч нарынхаа дунд итгэл, хайрыг бий болгохын тулд бүх зүрх сэтгэлээрээ анги эсвэл чуулгадаа оролцох орно. Түүнчлэн үүнд дуудлагаа баяр хөөртэй биелүүлэх орно.

Би Ютагийн Баунтифулд диконы чуулгад мөн Айдаход Ням гаргийн ангид зааж байсан олон ням гарагтаа талархадаг. Би бүр балчир хүүхдийн ангид эхнэртээ туслахаар үйлчилж байснаа мөн санадаг. Миний гол үүрэг тоглоомнуудыг тарааж өгч, хураах явдал байв.

Би олон жилийн өмнө Их Эзэнд үзүүлсэн миний энгийн нэгэн үйлчлэл Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн амьдралд чухал гэдгийг Сүнсээр дамжуулан мэдэж авсан юм. Гайхалтай нь, тэдний зарим нь Хүндэтгэлийн өдрүүдэд Эзэний төлөө өөрсдөд нь үйлчилсэн төгс бус оролдлогуудыг маань мартаагүй, талархсан билээ.

Бид заримдаа Хүндэтгэлийн өдөр хийж байгаа үйлчлэлийнхээ үр дүнг харж чаддаггүйтэй адил Их Эзэний бусад үйлчлэгчийн хамтын үр нөлөөг харахгүй байж магадгүй. Гэвч Их Эзэн хаант улсаа итгэлтэй, даруухан үйлчлэгчдээрээ дамжуулан чимээгүйхэн мөн нийтэд ил сурталчлахгүйгээр гайхамшигт мянган жилийн ирээдүй рүү барьж байгуулаар байгаа. Үүний өсөн нэмэгдэж

буй сүр жавхланг Ариун Сүнсний хүчээр л харах боломжтой.

Би цөөхөн хэдэн гишүүнээс гадна ганцхан манай гэр бүл явдаг Нью-Жерсигийн жижигхэн салбарын ариун ёслолд явж өссөн юм. 75 жилийн өмнө би Пеннсилванни эсвэл Филадельфиягаас очиж болох Нью-Жерси дэх цорын ганц Сүмийн байранд баптисм хүртсэн. Принстонд ганцхан жижиг салбар байсан бол одоо хоёр том тойрог байна. Мөн хэдхэн өдрийн өмнө мянга мянган залуус Пеннсилванний Филадельфийн ариун сүмийг онцгойлон адислах ёслолын өмнөх баярын үзүүлбэр үзүүлсэн билээ.

Би залуу эрэгтэй байхдаа бидний ням гараг бүр шүтэн бишрэхээр цуглардаг байсан Нью-Мексикийн Альбукерке дэх цорын ганц сүмийн байранд дүүргийн номлогчоор дуудагдаж билээ. Өнөөдөр тэнд ариун сүм мөн дөрвөн гадас байна.

Би Массачусеттсийн Кэмбриж рүү сургуульд явахаар Альбукеркег орхисон юм. Массачусеттс, Рөүд-Айлендад ганцхан сүмийн байр, нэг дүүрэг байсан. Би ихэвчлэн түрээсийн байранд юм уу засаж язалсан жижигхэн байшинд явагддаг байсан жижигхэн салбарт ариун ёслолын цуглаанд оролцохоор уг үзэсгэлэнт газрын толгод дундуур явдаг байв. Одоо Массачусеттсийн Белмонтод Бурханы ариун сүм байгаа бөгөөд гадаснууд хаа сайгүй байна.

Их Эзэн Өөрийнхөө Сүнснийг тэдгээр жижигхэн ариун ёслол дээр ирсэн хүмүүс дээр юүлж байсныг тэр үед би олж хараагүй. Би үүнийг мэдэрч байсан ч хаант улсаа байгуулж, алдаршуулах Их Эзэний төлөвлөгөөний цар хүрээ, цаг хугацааг харж чадаагүй. Нэгэн бошиглогч илчлэлтээр дамжуулан одоо бидний харж байгаа зүйлийг харсан. Бид тоогоор олон байхгүй ч, гагцхүү өсөн нэмэгдэж байгаа эерэг нөлөө нь л гайхамшигтай байх болно гэж Нифай хэлсэн.

“Мөнхүү улиран тохиох дор би Бурханы Хурганы сүмийг болгоов, энэ нь . . . тоогоороо цөөн байв. . .

Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Хурганы сүмийн гэгээнтнүүдийн дээр, мөн газрын гадаргуугаар нэг тархсан Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буух Бурханы Хурганы хүчийг болгоов; мөн тэд ялгуусан алдар суунд зөв шударга байдал хийгээд Бурханы хүчээр зэвсэглэсэн байв.”⁶

Энэ эрин үе дэх бидний нөхцөл байдал болон биднийг хүлээж буй боломжуудын талаарх үүнтэй төстэй бошиглолын тодорхойлолыг Сургаал ба Гэрээнд цэдэглэсэн байдаг.

“Хичнээн агуу адислалуудыг Эцэг гартаа байлгаж мөн та нарын төлөө бэлтгэснийг та нар хараахан ойлгоогүй байгаа билээ;

Мөн эдүгээ та нар бүх зүйлийг дааж чадах нь үгүй; гэсэн хэдий ч, зоригтой бай, учир нь би та нарыг удирдах болно. Хаант улс та нарынх болой, мөн үүн дээрх адислалууд та нарынх билээ, мөн үүрд мөнхийн баялгууд та нарынх бөлгөө.

Мөн бүх зүйлийг *талархалтайгаар* хүлээн авдаг тэрээр алдар суут болгогдох болно; мөн энэ дэлхийн зүйлүүд, тийм ээ, бүр зуу дахин, түүнд нэмэгдэх болно.”⁷

Бурханы адислал, хайранд талархдаг байхаас ирдэг өөрчлөлт Сүм даяар өсөн нэмэгдэж байгааг би мэдэрсэн. Энэ нь итгэлийг сорих цаг мөчид, бүр цаашид амьд явахад туслахыг Бурханаас гуйх цаг мөчид Сүмийн гишүүдийн дунд илүү өсөж байгаа мэт санагдаж байна.

Алмагийн хүмүүс үүрэхэд хүнд ачааг нуруун дээр нь тавьж байсан Амюлоны хэрцгийлэлд хүнд бэрхшээлийг туулж байсантай адил бидний туулж буй амьдралд мөн ийм мөчүүд байх болно.

“Мөнхүү улиран тохиох дор Их

Эзэний дуу хоолой тэдний зүдгүүрт үед ирж, өгүүлсэн нь: Тэргүүнээ өргөцгөө мөн тайтгарагтун, учир нь надад хийсэн та нарын гэрээний тухай би мэднэ; мөн өөрийн хүмүүстэй гэрээ хийж мөн тэднийг боолчлолоос чөлөөлөх болно би.

Мөн та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол, бүр та нарыг боолчлолд байх үед би түүнчлэн хөнгөлнө; мөн та нар цаашид миний гэрчлэгчид болон зогсох болно, мөн та нар, Их Эзэн Бурхан би өөрийн хүмүүст тэдний зүдгүүрт үед зочилдгийг та нар гарцаагүй мэдэж болохын би үүнийг хийх болно.

Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүсийн дээр тавигдаж асан ачаанууд хөнгөлөгдсөн байлаа; тийм ээ, тэд ачаагаа амархан дааж чадахын тулд Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн билээ, мөн тэд баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх таалуудад захирагдсан болой.”⁸

Биднийг Бурхантай хийсэн гэрээгээ сахисан үед, ялангуяа сахихад хүнд байгаа үед Түүний аль хэдийн бидний төлөө хийсэн зүйлд талархсан мөн итгэл гарган тэвчих хүч чадлыг гуйсан залбирлыг Тэрээр сонсож мөн хариулсан гэдгийн гэрч нь та бид юм. Тэр нэг бус удаа биднийг баяр жаргалтай мөн хүчирхэг болгож байсан.

Та нар талархлаа илэрхийлж, хүлээж буй сорилт бэрхшээлд өөрсдийгөө болон бусдыг хүчирхэгжүүлэхийн тулд Хүндэтгэлийн өдрийг сахиж, энэ өдөр шүтэн бишрэхийн тулд юу хийж болохоо бодож байж магадгүй.

Та Бурханы өөрт чинь өгсөн бүх зүйлд талархан, хувиараа болон гэр

бүлээрээ залбирснаар эхэлж болно. Их Эзэн Өөртөө болон бусдад үйлчлүүлэхийн тулд таниар юу хийлгэхийг хүсэж байгааг мэдэхийн төлөө та залбирч болно. Ялангуяа Их Эзэний таныг явуулахыг хүсэж байгаа ганцаардсан, тусламж хэрэгтэй байгаа хэн нэгнийг хэлж өгөх Ариун Сүнстэй байхын төлөө залбирч болно.

Тэр та нарын залбиралд хариулах болно гэдгийг би амлаж байна. Та нар хүлээн авсан хариултуудынхаа дагуу үйлдсэнээр Хүндэтгэлийн өдөр баяр баясгалантай байж, зүрх сэтгэл тань талархалаар бялах болно гэдгийг би амлаж байна.

Би Бурхан Эцэг та нарыг мэддэг мөн хайрладаг гэдгийг гэрчилж байна. Аврагч Их Эзэн та нарыг хайрласан учраас нүглийг тань цагаатгасан. Эцэг болон Хүү бошиглогч Иосеф Смит дээр ирэхдээ түүний нэрийг мэдэж байсантай адил та нарын нэрийг ч бас мэднэ. Энэ бол Есүс Христийн Сүм мөн Тэрээр та нарын Бурхантай хийж, шинэчилсэн гэрээнүүдийг хүндэтгэх болно гэдгийг би гэрчилж байна. Та нарын мөн чанар өөрчлөгдөн Аврагчийнхтай илүү адил болно. Та нар үнэний талаарх уруу таталт, эргэлзээний эсрэг зогсохоор хүчирхэгжих болно. Та нар Хүндэтгэлийн өдөр баяр баясгаланг олно. Би энэ бүхнийг Их Эзэн Есүс Христийн нэрээр амлаж байна, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. Сургаал ба Гэрээ 59-ыг үзнэ үү.
2. Сургаал ба Гэрээ 59:5, 7–8.
3. Сургаал ба Гэрээ 59:21.
4. “Адислал бүрээ тоол,” *Сүмийн дуулал*, 7-г үзнэ үү.
5. Моронай 4:3; 5:2; Сургаал ба Гэрээ 20:77, 79.
6. 1 Нифай 14:12, 14.
7. Сургаал ба Гэрээ 78:17–19; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
8. Мозая 24:13–15.

Бидэнд зориулсан сургаал

2016 оны 11-р сараас эхлэн 2017 оны 4-р сар хүртэл Мелкизедек санваартнууд ба Халамжийн нийгэмлэгийн дөрөв дэх ням гаргийн хичээлийг 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн нэг ба түүнээс дээш үгийг сонгон бэлтгэж заана. 2017 оны 4-р сард 4-р сарын эсвэл 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийн алийг нь ч сонгож болно. Гадас, дүүргийн ерөнхийлөгчид Ерөнхий чуулган дээр хэлсэн үгийг сонгож эсвэл энэ үүргийг бишоп, салбарын ерөнхийлөгчдөд даалгаж болно.

Эдгээр хэлсэн үгийг **conference.lds.org** хаягаар олон хэлээр унших боломжтой.



Ерөнхийлөгч Томас С.Монсон

Аз жаргалд хүргэх төгс зам

Би Эцэгийн төлөвлөгөө болох энэхүү агуу бэлгийн талаар гэрчилж байна. Энэ нь амар амгалан, аз жаргалд хүргэх цорын ганц төгс зам юм.

Энэ чуулганы төвд байгаа мөн дэлхий даяар байгаа хайрт ах, эгч нар минь, энэ өглөө та бүхэнтэй өөрийн бодол санааг хуваалцах боломжтой байгаадаа би ямар их талархаж байна гээч.

50 жилийн өмнө 1964 оны 7-р сард би Нью-Йорк хотод үүрэг даалгавар хүлээн авсан юм. Тухайн үед тэнд нэгэн олон улсын үзэсгэлэн худалдаа болж байлаа. Нэгэн өглөө эрт би тухайн үзэсгэлэн дээрх Мормон павилионд очих үед *Man's Search for Happiness* (Хүн төрөлхтний аз жаргалын эрэл) хэмээх авралын төлөвлөгөөг харуулсан нэгэн кино яг эхлэх гэж байлаа. Уг кино хожим нь Сүмд нэлээд нэртэй болсон. Би манай Сүмийн гишүүн биш, багцаалбал 35 настай байх гэмээр нэгэн залуугийн хажууд суусан ба бид товчхон яриа өрнүүлэв. Гэрэл бүдгэрч, кино ч эхэллээ.

Өгүүлэгчийг хамгийн чухал, түгээмэл асуулт болох “Би хаанаас ирсэн бэ? Би яагаад энэ дэлхийд байгаа вэ? Би энэ амьдралыг

орхисныхоо дараа хаашаа явах вэ?” гэх мэт асуултыг өгүүлэх зуур бид чих тавин сонсож суулаа. Тэнд байсан бүх хүн асуултын хариуг мэдэхийг тэсэн ядан хүлээж, дэлгэцэн дээрх зураглал руу нүд салгалгүй харж байв. Мөнх бус байдлын өмнөх амьдралын зураглал, дэлхий дээрх бидний амьдралын зорилгын тайлбартай хамт гарч ирлээ. Бид нэгэн өндөр настанг энэ амьдралаас хэрхэн явж байгаа мөн өөрийг нь сүнсний дэлхийд хүлээж байгаа хайртай хүнтэйгээ хэрхэн дахин нэгдэж байгаа сэтгэл хөдлөм зураглалыг харж байв.

Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан төлөвлөгөөний үзэсгэлэнт зураглал дуусах үед хүмүүс чимээгүйхэн гарч явцгаасан ба уг киноны санаа олон хүнд хүрсэн нь илт байлаа. Миний хажууд сууж байсан залуу суудлаасаа боссонгүй. Би түүнээс кино таалагдсан эсэхийг асуухад тэр “Энэ бүгд үнэн!” гэсэн баттай хариултыг надад өгсөн юм.

Манай номлогчид бидний аз

жаргал, авралд зориулагдсан Эцэгийн төлөвлөгөөг дэлхий даяар хуваалцаж байна. Энэхүү тэнгэрлэг захиасыг сонссон зарим хүн үүнийг хүлээн зөвшөөрч, дагадаггүй. Гэсэн ч Нью-Йоркийн үзэсгэлэн дээрх залуу найз шиг маань эрэгтэй, эмэгтэйчүүд газар сайгүй үүний үнэнийг мэдэж, гэр рүү нь аюулгүй хүргэх уг замыг дагахаар шийддэг юм. Тийнхүү тэдний амьдрал үүрд мөнхөд өөрчлөгддөг.

Бидний Аврагч, Есүс Христ энэ төлөвлөгөөний зайлшгүй нэгэн чухал хэсэг билээ. Түүний цагаатгагч золиослолгүйгээр хүн бүр төөрөлдсөн хэвээрээ үлдэх байсан. Зүгээр л Түүнд болон Түүний номлолд итгэх нь хангалтгүй юм. Бид хөдөлмөрлөж, суралцаж, эрэлхийлж мөн залбирч, наманчилж, өсөж хөгжих хэрэгтэй. Бид Бурханы хуулиудыг мэдэж, тэдгээрийн дагуу амьдрах хэрэгтэй. Бид Түүний авралын ёслолуудыг хүлээн авах хэрэгтэй. Бид эдгээрийг хийснээр л жинхэнэ, мөнхийн аз жаргалыг олж авах болно.

Бид үнэнээр *адислагдсан* ба уг үнэнийг *хуваалцах* үүрэгтэй. Эцэгийн бидэнд хадгалсан бүхнийг хүлээн авахын тулд уг үнэнээр *амьдарцгаая*. Түүний хийж буй бүх зүйл бидний сайн сайхны төлөө байдаг. Тэрээр “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө”¹ хэмээн бидэнд хэлсэн.

Би бодьгалынхаа бүхий л эрч хүчээр мөн даруу байдлын гүнд бидэнд зориулсан Эцэгийн

төлөвлөгөө болох энэхүү агуу
бэлгийн талаар гэрчилж байна. Энэ
нь энэ дэлхийд болон ирэх дэлхийд
амар амгалан, аз жаргалд хүргэх
цорын ганц төгс зам юм.

Ах, эгч нар минь, би та бүхэнд
өөрийнхөө хайр, адислалыг үлдээн,
үгээ төгсгөө. Би энэ бүхнийг бид-
ний Аврагч, Гэтэлгэгч Есүс Хрис-
тийн нэрээр үлдээж байна, амен.

Эшлэл

1. Моисе 1:39.